



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖЛИЙН САЙД С.ОЮУН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.04.24 № УАГ-ГАГ 07/63

Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээний хэрэгжилтийн үр
дүнг ирүүлэх тухай.

БОНХС таны багцад хамарагдах “Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийх явцад ЗГХА Усны газар нь 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дорноговь аймгийн Өргөн сумын нутаг Долоодын говьд “Сайншанд” аж үйлдвэрийн паркийн усан хангамжийн нэмэгдэл эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны урьдчилсан хайгуулын гидрогеологийн судалгааны ажил”-ыг 2012 оны 6 дугаар сарын 18-наас 2012 оны 12 дугаар сарын 20-ны хооронд “Нью гидро проект” ХХК-аар хийж гүйцэтгүүлэхээр гэрээ хийж, 140.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон боловч энэ ажлыг гүйцэтгээгүй зөрчил илрэв.

Гэрээнд захиалагчийг төлөөлж Усны нөөцийн хэлтсийн дарга Д.Өнөржаргал, гүйцэтгэгчийг төлөөлж Б.Зоригто нар гарын үсэг зурж, Усны газрын дарга Ц.Бадрах, “Нью гидро проект” ХХК-ийн захирал Б.Зоригто нар баталгаажуулж, улмаар 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдөр БОНХЯ-ны ТНБД Ж.Батболд, яамны СХОХ-ийн дарга Д.Цэцгээ нарын гарын үсэг зурсан 23 тоот төлбөрийн хүсэлтээр шилжүүлжээ.

Гэтэл санхүүжилт авсан “Нью гидро проект” ХХК гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй бөгөөд дараах зөрчилтэй зүйлүүд ажиглагдлаа. Үүнд:

- Тус компани Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15, 16, 20, 43, 44, 47 дугаар зүйлийн заалтуудыг бүрэн хангаагүй бөгөөд 2012 оны 1, 2, 3 дугаар улирлын болон жилийн эцсийн тайлан тэнцэл гаргаагүй, хайгуулын болон өрөмдлөгийн ажил хийж техник хэрэгсэл, мэргэжлийн ажиллагсад байхгүй, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлээгүй, компанийн байршил, хаяг, тодорхойгүй, гэрээнд бичигдсэн утас холбогдох боломжгүй байв.
- Усны газар нь дээрх ажлыг хийж гүйцэтгүүлэхээр 2 ч удаа тендер зарласан боловч шаардлага хангасан тендер ирээгүй гэдэг шалтгаанаар “Нью гидро проект” ХХК-тай гэрээг шууд байгуулсан байна.

079211

- Захирал Б.Зоригоо нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй атал “Нью гидро проект” ХХК-ийг худалдан 2013 оны 2 дугаар сарын 6-ны өдөр иргэн А.Амундрад эрх, үүрэг шилжүүлсэн боловч гэрээ хийсэн байгууллага буюу БОАЖЯ-нд албан ёсоор мэдэгдэж, гэрээнд өөрчлөлт оруулаагүй, авсан урьдчилгааг буцаан өгөх ажиллагаа хийгдээгүй байна.
- Б.Зоригоо, Т.Гансух нарын иргэн А.Амундрад худалдсан хувьцаа худалдах, худалдан авах гэрээний 4.1-т Компанийн үйл ажиллагаанаас үүсэх хариуцлагыг дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:
 - 4.1.1-т “Компанийн эрх шилжүүлэхээс өмнөх үеийг компанийн эрх шилжүүлэгч тал хариуцна”
 - 4.1.2-т “Компанийн эрх шилжүүлсэнээс хойши үеийг компанийн эрхийг шилжүүлэн авагч тал хариуцна” гэж заасан нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх эсэх нь эргэлзээтэй болжээ

Тус компанийн захиралаар ажиллаж байсан Б.Зоригоос хийсэн ажлын гүйцэтгэл болон компаний байгуулагдсан үеэс өнөөг хүртэлх хугацааны банк дахь харилцах дансны ажил, гүйлгээний хуулгыг хэвлүүлэн авч ирэхийг удаа дараа шаардсан боловч тамга тэмдэг байхгүй, шилжүүлэн авсан иргэн Амундра нь гадаадад явсан гэх мэтээр шалтаг заан шаардсан зүйлийг гаргаж ирүүлээгүй болно.


Иймд Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15.1-ийн 12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх,...” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Долоодын говьд “Сайншанд” аж үйлдвэрийн паркийн усан хангамжийн нэмэгдэл эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны урьдчилсан хайгуулын гидрогеологийн судалгааны ажил”-ыг хийж байгаа гэх боловч ажлын гүйцэтгэлийг БОНХЯаманд одоогоор ирүүлээгүй байна. Хэрэв гэрээт ажлыг гүйцэтгэсэн гэж үзвэл тус яамны “Усны нөөцийн зөвлөл”-ийн хурлаар 2013 оны эхний хагас жилд багтаан хэлэлцүүлж, зөвлөлийн тогтоолоор баталгаажуулан гэрээний биелэлтийг тооцох
2. Хэрэв “Усны нөөцийн зөвлөл”-ийн хурлын тогтоолоор хэрэгцээ шаардлага хангахгүй, хагас дутуу, чанаргүй ажил гүйцэтгэсэн гэж үзвэл иргэн Б.Зоригоо өөрийн хөрөнгөөр дахин хийх, эсвэл улсын төсвөөс олгосон 140,0 сая төгрөгийг буцаан төлөх
3. Долоодын говьд “Сайншанд” аж үйлдвэрийн паркийн усан хангамжийн нэмэгдэл эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны урьдчилсан хайгуулын гидрогеологийн судалгааны ажил”-ыг хийж гүйцэтгэх зориулалтаар СЯ-наас БОНХЯ-ны хөрөнгө оруулалтын харилцах дансанд байршуулсан 60.0 сая төгрөгийг улсын төсвийн орлого болгох
4. Долоодын говьд “Сайншанд” аж үйлдвэрийн паркийн усан хангамжийн нэмэгдэл эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны урьдчилсан хайгуулын гидрогеологийн судалгааны ажил”-ыг хийж гүйцэтгэсэн тохиолдолд гэрээг албан ёсоор дүгнэж, гэрээний хэрэгжилтийг Иргэний тухай хуульд заасан заалтын дагуу хариуцлага тооцож ажиллах

5. Гэрээт ажлыг хийхээр 140.0 сая төгрөгийн урьдчилгаа авсан ажлын гүйцэтгэл, түүнийг хүлээн зөвшөөрсэн албан ёсны шийдвэр, холбогдох баримт материал, ажлын үр дүнг Үндэсний аудитын газарт 2013 оны 7 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор хариу мэдэгдэхийг БОНХЯ-ны ТНБД Ж.Батболд, тус яамны СХОХ-ийн дарга Д.Цэцгээ, "Нью гидро проект" ХХК-т компанийн захирлаар ажиллаж байсан Б.Зоригоо нараас ШААРДАЖ байна.


Албан шаардлага

Бичсэн

Үндэсний аудитын газрын ГАГ-ын
ахлах аудитор

Г.Цэдэнбалжир
Нийцлийн аудитын тазрын
аудитор
Э.Уянга
УХА0122

Танилцаж, зөвшөөрсэн
БОНХЯ-ны ТНБДарга
Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга
Ж.Батболд
Д.Цэцгээ

"Нью гидро проект" ХХК-ийн захирлаар
ажиллаж байсан



Б.Зоригоо